



Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт үлгэр V: Утгын тайлал II

Өмнөх нийтлэлд бид Есүсийн алдарт сургаалт зүйрлэлийн баян хүн, ядуу Лазар хоёрыг чухам хэн болохыг, хаашаа очсоныг авч үзэн тайлсан. Ертөнцийн Эзэний нүүр буруулснаас болж үл үзэгдэх байдалд орсон иудейчүүдийг баян хүн билэгддэг. Харин ядуу Лазар энэ хорвоод Ертөнцийн Эзэнгүйгээр явснаа гэнэт Абрахамын итгэлийн хүүхдийн байранд шилжиж орсон үндэстнүүдийн хүмүүсийг хэлнэ. Энэ нийтлэлд бид үлгэрийн баян хүн, Абрахам хоёрын ярианы утгыг тайлахыг зорино.

Хурууны үзүүрийн туслалцаа, гал асаадаг хэл

Баян хүн ядуу Лазарыг ядахдаа “хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг” гэж хүссэн (Лук 16:24).



Энэ нь фарисайчуудын тухай Есүсийн нэгэн үгийг санаанд оруулна. Үүнд: фарисайчууд “үүрэхэд бэрх хүнд ачаа баглаж, хүмүүсийн мөрөн дээр тавьдаг атлаа өөрсдөө үүнд хуруугаа ч хүргэхийг хүсдэггүй” гэж хэлсэн (Матай 23:4, Лук 11:46).


Ядуучуудад хурууны үзүүрээр ч гэсэн туслахаас татгалзсан ихэмсэг бардам иудей ахлагч нарыг баян хүн билэгддэг билээ. Тэгэхээр Абрахамынх биш, ад үзэгдсэн еврей бус хүний тусламжийг гуйж байгаа нь анхаарал татаж байна.



Хэлний талаар Исаагийн бичсэн нэг үг бий. Үүнд:
**“Ам хэл, ажил үйл нь ИАВЭгийн эсрэг байсан тул
Алдар суут оршихуйг нь доромжилсон учир
Иерусалим бүдэрч, [Иуда] унажээ”** (3:8).

Иудейчүүд юун түрүүн ам хэлээрээ Аврагч Эзэнээ эсэргүүцэж, Түүний Оршихуй болох Есүсийг доромжилсны улмаас Иерусалим хот “бүдрэн унасан” хэмээн дээрх зөгнөлөөс ойлгогдож байна. Энэ нь МЭ 70 онд биелсэн билээ. Иудейчүүдийн хэл өөрсдийн

хайртай ариун
Хотыг үнсэн
товрог болоход
хүргэсэн гэсэн үг.
Давид бичихдээ,
**“Хэрвээ би
Иерусалимыг
Өөрийн хамгийн
дээд
баясгалангаас
илүүгээр**



**өргөмжлөхгүй бол Хэл минь тагнайнд минь
наалдаг”** (Дуулал 137:6). Баян хүний хэл өөрийг нь зовоосон нь гайхах юмгүй.

Гэтэл иудейчүүд Иерусалим хотыг ам хэлээрээ унагаагаад зогсохгүй, ам хэлээрээ алуурчин Барабыг өөрсөддөө сонгож, харин Аврагч Хаанаа үгүйсгээд зогсохгүй, “Түүнийг цовдол!” гээд шаардан хашгирсаар байж алуулахад хүргэсэн (Матай 27:21-23). Ийнхүү тэд Есүст гар хүрээгүй ч Түүнийг “бурхангүй хүмүүсийн гараар загалмайд хадуулж, алсан” гэж энэ үгээр Петр иудейчүүдийг л буруутгадаг (Үйлс 2:23). Үнэхээр



“Тэдний хоолой нь онгорхой булш юм. Тэд хэлээрээ зусардаг”. “Тэдний уруул дор могойн хор байдаг” гэсэн үгс тэр өдөр биелжээ (Ром 3:13).

Иудейчүүд ам хэлээрээ Есүсийн цаазлахыг шаардаж байхдаа **“Түүний цус бидний болон бидний үр хүүхдүүдийн дээр байг”** гэжээ.



Энэ үгээрээ тэд өөрсдийнхөө хүссэн хүлээсэн Аврагчийг хороохоос гадна ирээдүйн олон зууны турш эдлэх хэцүү зовлонг өөрсдийн үе удмынхаа толгой дээр тунхаглан авчирдаг (Матай 27:25). Үүнийг бодохоор мөнөөх баян хүн зовлонгийн газарт орохдоо гомдол гаргаж, өөрийгөө өмөөрөхийг огт оролдоогүй нь ойлгомжтой.

Энэ бүхнээс харахад баян хүн чухам яагаад хэлээ л сэрүүцүүлэхийг бодсон нь ч ойлгомжтой боллоо. Ганц л бяцхан цогноос болж бүхэл бүтэн ой мод шатан, түймэрт цөлмүүлэх аюултай. **“Гал түймэртэй адил” болох хэл яриа маань “бүхэл бүтэн гэмт ертөнцийг бүрдүүлж байдаг”** (Иаков 3:6, ББ). Өөрөөр орчуулбал, **“Хэл бол гал бөгөөд... бидний амьдралын хүрдийг галдан шатаадаг...”** (АБ). Баян хүний тарчлан буй “гал” өөрийнх нь хэлээр асан дүрэлзээд байгаа юм.



Бид бүгд өөрийн ам хэлнээсээ болоод хэрэгт орж үхтлээ санаа зовж, ичээд, харамсаад, өөртөө уурлаад өөрийгөө буруутган үзэн ядахын дээр янз бүрийн үр дагавар амсаад ер нь бие сэтгэлээрээ маш их зовж үзсэн учраас энэ дүрслэлийг сайн ойлгоно.

Жижиг эрхтэн боловч, **“үхлийн хороор дүүрсэн” “хэл нь... бүх биеийг бузарладаг.”** (Иаков 3:5-8).

“Аманд орсон юм хүнийг бузарладаггүй, харин амнаас гарч буй нь хүнийг бузарладаг юм” гэсэн Есүсийн үг юутай үнэн вэ (Матай 15:11, 18-20; 7:20-23). Ертөнцийн Эзэнийг хүндэлдэггүй хүмүүсийн сайрхдаг хэлний тухай Давид хаан бичихдээ: **“ИАВЭ харин зусар уруул бүрийг хамхиг. Ихэрхэг хэл болгоныг таслаг. “Хэлээрээ бид ноёлно, уруулаараа бид дуугарна. Хэн биднийг захирах юм бэ!” гэж тэд хэлж байна.”** (Дуулал 12:2-4)

Иймд **“Ам хэлээ хазаарлагч нь Аюул зовлонгоос биеэ [еврей: сэтгэлээ] хамгаална.”**
(Сургаалт үгс 21:23)

Тэгвэл: **“Үг хэлийг минь хянаж сэргийлээч. Уруул амыг минь манаж цагдаач, ИАВЭ!”**
хэмээн гуйя
(Дуулал 141:3).





Үнэнг ойлгох ойлголт руу нэвтрүүлэхгүй ангал

Баян хүний хүсэлтээс Абрахам татгалзан, “эндээс наана чинь очих, наанаас чинь энд ирэхийг хүсэгчдийн хэн ч ирж, очиж үл чадах тийм гүн ангал чи бидний дунд тогтжээ” гэж тайлбарладаг (Лук 16:26). Баян хүнийг өөрийнх нь хэлээр ассан гал дотор хорьдог тэр ангал юу байж болох вэ?



Ертөнцийн Эзэний Хуулийн дагуу хүн гэмийг “санаатай хийсэн бол... ИАВЭг доромжлон гутааж буй хэрэг юм. Тэр хүн ард түмнээсээ таслагдана” (Тооллого 15:30). Баян хүнийг өвөг Абрахамаасаа хорьдог гүн ангал нь Ертөнцийн Эзэний ард түмнээс таслагдсан байхыг илэрхийлэх нь ойлгогдож байна.

“Би энэ ертөнцөд шүүлтийн төлөө ирсэн нь хардаггүйг хардаг, харагсдыг сохор болгохын тулд юм” гэж Есүс нэг удаа хэлэхэд зарим фарисайчууд өөрсдийгөө сохор биш гэж дургүйцэн сөргөлдөв. Үүнд Есүс хариулж, **“Та нар үнэхээр таг сохор байсан бол, гэмгүйд тооцогдож болохсон. Гэтэл та нар өөрсдийгөө бүхнийг мэднэ гэж тооцдог болохоор гэмтэй хэвээрээ үлдэцгээнэ”** (Иохан 9:39-41, ББ). Энэ үгээрээ Есүс өнөөх баян (иудейчүүд), ядуу Лазар (бусад үндэстэн) нарын байр хэрхэн,



яагаад солигдсон талаар сэжүүр өгч буй мэт. Өнөөх ангал Ертөнцийн Эзэний чөлөөлөгч үнэнг олж харж чадахгүй зүрх сэтгэлийн сохрийг дүрсэлж, тэрхүү хараагүй байдлыг буй болгодог хүний омог бардам зангаар бүрддэг билээ.

Паул мөн адил иудейчүүдийн сохор байдал нь юу ч ойлгодоггүй цэвдэг хатуу зүрх сэтгэлээс нь үүдэхийг хэлсэн. **“Израильчуудын зүрх сэтгэл хатуурсаар өнөөдрийг хүртэл өөрчлөгдөөгүй цэвдэг хатуу хэвээрээ байна. Тэд хуучин гэрээг өдий болтол уншсаар байгаа ч [Мосегийн] адилаар нүүрээ бүтээсэн мэт юу ч ойлгох чадваргүй хэвээр байгаа ажээ. Учир нь гэвэл, зөвхөн Христ л тэрхүү бүтээлгийг хуу татан авч чадах юм. Тиймээ, өнөөдрийг хүртэл тэд [Мосегийн] дамжуулсан хуулийг уншсаар байвч зүрх сэтгэл нь үнэндээ бүтээлэгтэй нүүр шиг л хаалттай хэвээр байгаа болно”** гэжээ (2 Коринф 3:14-15, ББ. Маарх 6:52; 8:17-г үзнэ үү).



Өнөөх гүн ангал бол еврейчүүдийн ойлгох чадварыг хаадаг тэр бүтээлгээс ялгаагүй юм. Баян хүний таван дүү нарт, фарисайчуудын сэтгэлд ч гэсэн Мосе ба эш үзүүлэгчдийн үгс яагаад хүрч, аврал болж чадаагүй нь ингээд илэрхий болж байна.

Энэхүү ангалыг хөдөлшгүй тогтоосон нь Ертөнцийн Эзэн Өөрөө. Тэрээр Өөрийн ард түмнээ **“зөрүүд хатуу зүрх сэтгэлтэй хүмүүс болголоо. Энэ тухай Ертөнцийн Эзэний сургаалд бичихдээ, «Ертөнцийн Эзэн тэднийг юм ойлгох чадваргүй болгожээ.**



Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай • 7

Тэдний нүд нь харах чадваргүй, чих нь сонсох чадваргүй болоод өдий болтол тэр л хэвээрээ үлджээ» гэсэн байдаг. Мөн Давид хаан энэ тухай хэлэхдээ «... Үнэн байдлыг нь тэдэнд үзүүлэхгүйн тулд харах нүд нь харанхуйлах болтугай! Үүрч яваа зовлонгоосоо болоод ууц нуруу нь бөхийх болтугай!» гэжээ” (Ром 11:7-10, ББ).

Үхсэн хүнийг Ертөнцийн Эзэнээс өөр хэн ч амилуулж чадахгүйн адилаар Ертөнцийн Эзэний сохолсон нүдийг Түүнээс өөр хэн ч нээж чадахгүй. Тэр бүтээлгийг зөвхөн Есүс хуу татаж авах учраас итгэгч бид хүссэн ч тийм бүтээлгийн дор яваа хүнд үнэнийг ойлгуулж чадахгүй. Мөнөөх ангальг Абрахамын талаас ч гаталж болдоггүйн учир энэ.

Өнөө ангал Иордан голыг ч билэгдэнэ

Библийн монгол орчуулгаас харагдахгүй нэгэн санаандгүй баримт нь үлгэрийн ангал дүүрэн ус болоход оршино. Лук 16:26-д “хэн ч ирж, *очиж* үл чадах тийм гүн ангал” гэж орчуулсныг грек эхээр шалгаж үзвэл АБ-



ийн “очиж” гэж орчуулсан үг нь (G1276) гол юмуу нуурыг “гатлах” гэсэн утгатай. «Шинэ Гэрээ»-нд 6 удаа гардаг энэ үгийн хэрэглээг үзвэл бусад 5 тохиолдолд үргэлж усан онгоцоор нуур, далайгаар явж туулан гатлахыг хэлнэ (Матай 9:1, 14:34, Маарх 5:21, 6:53, Үйлс 21:2).



Мөнөөх гүн ангал ус дүүрэн байгаа нь үнэхээр сонирхол татаж байна. Үлгэр маань бодит түүх байсан бол галд шатаж буй баян ердөө л тэр ангал дүүрэн усанд шумбан орж, хэл төдийгүй бүтэн биеэ сэрүүцүүлж тайвширч болохсон. Гэвч Есүс энэ өгүүллэгээрээ бодит түүхийг яриагүй, грек шашнаас орж ирсэн домгийн ойлголтоор доог тохуу хийнгээ чухал сургаал зааж байгаа нь дахин батлагдаж байна.

Тус ангал ямар ач холбогдолтойг олж мэдэхийн тулд “аврал, шагнал эсвэл шийтгэлтэй холбоотой ус дүүрэн газарзүйн ангал Библид гардаг уу?” гэж асуух нь тустай. Хайж үзэхээр тийм газар үнэхээр бий! Иордан гол гүн ан хавцал болох Иордан хагарлын хөндийд урсдаг. Тэр газрын хагарал Түркийн өмнөх хилээс эхэлж Иордан гол, мөхсөн тэнгис, өмнөд Араба цөлийн дундуур гарч, Акабагийн буланг бүрдүүлж улаан тэнгист ордог.



Иордан гол нь Их Эзэний Абрахамд амласан газар нутгыг бусад үндэстний нутгаас тусгаарладаг. Иймээс израилчууд Амалсан Нутагт орохын тулд Иордан голыг гатлах шаардлагатай байсан. Мосе нэг гэмээсээ болоод Амалсан Нутагт орох эрхгүй болсон тул тэр голоор гаталж чадаагүй (Тооллого 20, Дэд хууль 3:23-28; 4:21-22; 31:1-3; 34). Израилчуудыг тэр гол дундуур дагуулж, Амалсан Нутаг руу оруулсан нь Иошуа.



Энэ еврей нэрийн грекжүүлсэн хэлбэр нь “Есүс” билээ. Ингээд Иордан гол Ертөнцийн Эзэний амласан бүхэнд оруулах үүд хаалга мэт бөгөөд тэр хаалгаар хэн орохыг зөвхөн Ертөнцийн Эзэн шийддэг. Иордан гол нь энэ дэлхийгээс тусгаарлагдан, Ертөнцийн Эзэний амласныг хүртэхийн бэлэг тэмдэг. Есүсийг дагаж, тэр голыг нэг ёсондоо гатласан хүн хуучин амьдралаа ардаа орхиж, Ертөнцийн Эзэний шинэ амьдралтай болж улмаар Түүний Хаант Улсад ордог. Өөрөөр хэлбэл, Иордан голыг гатлах нь авралыг билэгддэг.

Есүсийн өгүүлэлд Абрахамын сууж буй, Иордан голын ангалын нэг тал нь түүнд амласан Нутаг буюу өөрт нь өгөгдсөн Ертөнцийн Эзэний бүх амлалт биеллээ олох мянган жилийн Хаант Улсыг бэлэгдэнэ. Үнэн итгэлт Лазар өвөрт нь сууж байгаа нь Абрахамын хүртсэн амлалтуудыг хуваалцдаг болсныг илэрхийлнэ. Гэвч өнөөх баян Иордан голын ангалын буруу талд хоцрохдоо Их Эзэний амлалтуудаас ч хоцорсон.

Үхлээс амилсан Лазарыг алахыг хүйвалдсан нь

Баян хүн эцэст нь Лазарыг дүү нар луу нь илгээхийг Абрахамаас гуйдаг (Лук 16:27). Абрахам хариуд нь тэд Мосе, эш үзүүлэгч нарыг (буюу тэдний бичиж үлдээсэн сургаалыг) анхааран дагах хэрэгтэй гэдэг. Ертөнцийн Эзэний Үг үхлээс амилсан хүний үгээс ч илүү эрх мэдэлтэй болохыг Есүс энэ замаар дам илэрхийлсэн. Нас барж тамд юмуу диваажинд очоод эргэж ирснээ ярьдаг хүмүүс өнөө үед олон бий. Ийм яриа Ертөнцийн Эзэний Үгтэй зөрчилддөг. Бид дахин амилснаа ярьдаг этгээдээс илүү Ертөнцийн Эзэний Үгэнд итгэх ёстой.



Гэтэл өнөөх баян, үхэгсдээс хүн ирж уулзах л юм бол дүү нар нь анхаарч, гэмээсээ сална гэж үзсэн хэвээрээ. Үүнд Абрахам: *"Хэрэв тэд Мосе ба Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ"* гэж өчдөг. Абрахамын энэ үгийн үнэнийг Есүс хэсэг хугацааны дараа бодитойгоор батлан харуулсан.


Түүний үхэгсдээс дахин амилуулсан хүнээс нэгнийх нь нэр л тэмдэглэгдсэн. Тэр бол Марта, Мариа хоёрын ах Лазар! Найз Лазараа өвдсөн болохыг Есүс сонссон хирнээ шууд очиж эдгээгээгүй. Иймээс Лазар нөгөө үлгэрийн Лазар шиг нас барсан. Гэтэл дараах нөхцөл байдал нь эрс өөр. Үлгэрийн Лазар оршуулагдсан шинжгүй, шууд биеэрээ Абрахамын өвөр дээр очсон бол жинхэнэ Лазарыг оршуулахад шарилыг нь боолтоор ороож, нүүрийг нь алчуураар бүтээгээд хадан булшинд тавьж, үхэр чулуугаар хаасан. Шарил нь бүр өмхийрч эхэлсний хойно л Есүс зорьж очоод Лазарыг тэр л булшнаас дуудан гаргаж, эргээд амилуулдаг. Лазар диваажинд орж, тэнд Абрахамтай



уулзаж, баян "хөршөө" галд тарчилж буйг харсан бол энэ талаар хүн бүрт ярьж сануулж өгмөөр санагдана. Гэвч Лазар нэг ч үг дуугараагүй нь өөрөө тэр л булшинд амьгүй хэвтэж байсны том сэжүүр билээ.



Олон хоногийн өмнө нас барсан хүн олны нүдэн дээр булшнаас гарсан энэ гайхамшигийг үгүйсгэхийн аргагүй байжээ. Фарисайчууд бүгд энэ явдлын тухай сонссон. Яалт ч үгүй үхмэл байсан энэ хүнийг Есүс үхэгсдээс амилуулсанд ямар ч эргэлзээ алга.



Гэвч тэд Есүст итгэж, гэмээсээ салахын оронд харин ч Түүнийг барьж аваад алуулах хуйвалдаан зохиож эхэлсэн! Хоорондоо зөвлөлдөж байх үедээ баян хүний дүрд тохирох тэргүүн тахилч Каиаф: “Есүс бүх ард түмний өмнөөс ганцаараа алагдсан нь дээр” гэж хэлсэн. Энэ болсон явдлыг Иоган 11-р бүлгээс уншаарай.

Тэгээд үүгээр ч барахгүй, фарисайчууд үхэгсдээс амилсан Лазарыг ч алахаар шийдсэн (Иохан 12:10)!

Ингээд Ертөнцийн Эзэний

ажлыг эсэргүүцдэг зүрх сэтгэл нь бүрэн илэрсэн.

Абрахамын сургаалт үлгэрт хэлсэн үг бол фарисайчуудыг шууд хэлж зөгнөсөн үг байлаа.

Моце ба эш үзүүлэгчид Есүс Христийг гэрчилдэг

“Үхэгсдийн дотроос амилах хүн байсан ч түүний үгийг сонсохгүй биз” хэмээх Абрахамын амаар хэлсэн Есүсийн зөгнөл ганц биш, хоёр ч удаа биелсэн билээ.



Есүс фарисайчуудад: **“Та нар бичвэрүүдэд мөнх амь бий гэж боддог тул тэднийг нягталдаг. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ... Хэрэв та нар Мосед итгэсэн юм бол Надад итгэх байсан. Учир нь тэр Миний тухай бичсэн юм. Харин та нар түүний судар бичигт итгэхгүй бол үгэнд минь яаж итгэх билээ?”** гэжээ (Иохан 5:39, 46-47. Энэ талаар мөн Дэлгэрэнгүй Хууль 18:18-19 + Иохан 12:49; Лук 24:27, Иохан 1:45, Үйлс 3:22-24, 7:37, 26:22-23, 28:23 уншина уу.)

Ийнхүү Мосе болон эш үзүүлэгч нарын бичсэн үг, Есүс өнөөх амалсан Аврагч мөн болохыг таньж итгэхэд хангалттай үндэслэл байтал ихэнх еврейчүүд, ялангуяа Бичээсүүдийг нарийн судалдаг фарисайчууд итгээгүй нь хачирхалтай! Гэвч Мосегийн үгэнд тэд нэгэнт итгээгүй учраас Есүс хожим дахин амиллаа ч Түүний үгэнд итгэхгүйг Есүс энд хэлсэн нь тодорхой.

“Мосегийн Хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” гэж Есүс дагалдагч нартаа тайлбарласан (Лук 24:44). Паул мөн адил **“...эш үзүүлэгчид болон Мосегийн хэлсэн нь биелэх ёстой... Энэ бол Христ зовлон эдэлж, үхэгсдээс хамгийн түрүүн амилснаар манай ард түмэнд төдийгүй харийнханд гэрлийг тунхаглана гэсэн үг юм”** хэмээн тайлбарладаг (Үйлс 26:22-23). Тэр л үгийн дагуу л Есүс **“Би нас бараад гурван хоногийн дараа дахин амилна”** гэж хэлсэн.

Түүний энэ үгийг Израилын томчууд мэдээгүй биш, мартсан биш, харин ч сайн санасан учраас булшийг нь манаж хамгаалах харуул тавьсан (Матай 27:63-66).



Гэвч хичнээн олон цэрэг тавьсан ч тэд Есүсийн үхлээс амилахыг хориглон цагдаж чадаагүй нь мэдээж. Есүсийн үг хэрхэн биелснийг фарисайчууд, үхтлээ айсан манаач цэргүүдээс шууд сонссон ч Түүнд итгээгүй хэвээр, харин ч булш дээр болсон явдлыг нууж, худал хуурмагаар далдлах гэж цэргүүдэд хахууль өгсөн. “Шавь нар нь шөнө ирээд, биднийг унтаж байх зуур Түүнийг хулгайлчихлаа” гэсэн тэдний гаргасан худал “иудейчүүдийн дунд энэ өдрийг хүртэл өргөн тархсан байна” (Матай 28:11-15).



Есүсийг загалмайд цовдлогдсоны дараахан дагалдагч нар нь иудей ахлагч нараас амь насандаа айн, нуугдаж байсан (Иохан 20:19). Гэтэл гурав дахь өдөрт Есүс хаалга нь түгжээтэй байсан тэр өрөөнд гэнэт дунд нь үзэгдэн, өөрийнхөө үхлээс амилсныг тэдэнд биеэрээ нотлов. Ингээд айдас дүүрэн байсан дагалдагчид Есүсийн үхлийг даван туулсныг гэрчлэх гэрч болж, Түүний тухай энд тэндгүй бүх еврейчүүдэд зоригтойгоор зарладаг болсон («Үйлс» номыг үзнэ үү). Тэгсэн ч гэсэн ихэнх иудейчүүд үгийг нь хүлээж аваагүй. Өнөөдөр ч ихэнх еврейчүүд рабби багш нарынхаа фарисай сургаалыг дагадаг учраас Мосе болон зарлагуудын үгэнд ч итгэдэггүй, үхэгсдээс амилсан Есүст ч итгэдэггүй. Ийнхүү Абрахамын зөгнөлт үг үнэн болох нь бүрэн батлагдсан (Лук 16:31).

“Мосе болон эш үзүүлэгч нарыг сонсог” гэж хэлсэн Абрахамын сүүлчийн үг бас өнөө үеийн итгэгч бидэнд



хамаатай. Мосе болон зарлагуудын үгэнд бид итгэх ёстой. Тухайлбал, үхлийн тухай тэдний бичсэн бүхэнд бид итгэдэг бол хэзээ ч энэ үлгэрийг болсон явдал гэж бодохгүй байхсан. «Хуучин Гэрээ»-нд бичсэн Ертөнцийн Эзэний үнэн сургаал «Шинэ Гэрээ»-нд бичсэн зүйлийн үндэс суурь билээ. Тэр Үнэнд итгэдэггүй юм бол яаж тэр л Үнэний дагуу нас барж, дахин амилсан Есүс Христэд үнэн утгаар нь итгэх билээ!

Үхэгсдийн оронд буй хүнд найдвар байхгүй юу?

Есүс өгүүллэгээ Абрахамын сөрөг үгээр гэнэт дуусгасан нь Түүний үгээрээ дүрсэлж буй зураглал нэг л дутуу орхисон мэт санагдана. Бидэнд лав нэгэн асуулт тулгардаг. Үүнд: *Энэ баян хүнд ямар ч найдвар байхгүй юу? Ертөнцийн Эзэн Өөрийнхөө сонгосон, олон гайхамшгтай амлалт өгсөн ард түмнээ үнэхээр мөнхийн мөнхөд хаясан гэж үү? Амалснаа биелүүлэхгүй гэж үү? Үхэгсдийн Оронд буй хүн дахин амилахгүй гэж үү?*

Эдгээр асуултыг Паул Ром 11-т тавьж, тодорхой хариу өгдөг: “**«Ертөнцийн Эзэн өөрийнхөө ард түмнийг голсон хэрэг үү?» гэдэг асуулт гарч байна. Огтхон ч үгүй! ... Ертөнцийн Эзэн анх сонгож авсан ард түмнээ тэр чигээр нь голоогүй... Тэгвэл, Ертөнцийн Эзэнд тийнхүү гологдон хаягдахдаа тэд дахин хэзээ ч өндийн босохгүйгээр уналаа гэсэн үг үү?** гэдэг асуулт байна.

Огтхон ч үгүй! Өөрсдийнх нь гэм буруутай байдлаас болоод өөр үндэстнүүд аврал олохыг нь харахдаа Израильчуудын атаархал төрөх болно [Дэд Хууль 32:21 дахь Мосегийн зөгнөлийг үзнэ үү]...



Тэд ийнхүү Есүст
итгэхээс татгалзсан нь
[АБ: тэдний огоорол нь]
даян дэлхийн бусад
үндэстнүүдийг
Ертөнцийн Эзэнтэй
эвлэрүүлэх байдалд
хүргэсэн бол, тэд



Есүсийг хүлээн зөвшөөрөх нь үхэгсдийг дахин
амилуулсантай тэнцэхүйц гайхалтай сайхан үйл
явдал болох юм..." (Ром 11:1,2,11,15 ББ).

“Тэдний огоорол” гэсэн орчуулга нэг бол тэд өөрснөө
Есүсийг хаясан, нэг бол тэд Түүнд хаягдсан гэсэн
утгатай. Аль нь ч зөв. Тэд нүүрээ Аврагч Эзэнээс
буруулсан учраас тэднээс Их Эзэн мөн адил нүүрээ
буруулж орхисон. Гэтэл Израилын үхэгсдээс дахин
амилах өдөр айсуу байна. Энэ талаар Их Эзэн
биднийг мэдээсэй гэж хүсдэг. Үүнд:

**“Ахан дүүс минь ээ! Өөрсдийгөө үнэн байдлаасаа
хэт үнэлэн үзэж, цэцэн цэлмэг болсон мэтээр
дэврүүлэн бодохоос та бүхнийг болгоомжлуу-
лахын тулд би нэгэн нууцыг тайлан ойлгуулах
гэсэн юм.**

**Зарим Израильчуудын зүрх сэтгэл ийнхүү зөрүүд
хатуу болсон нь *зуурдын хэрэг* мөн. Есүст итгэн
Ертөнцийн Эзэний авралыг үзэх Еврей бус
үндэстнүүдийн тоо толгой гүйцэх тэр үеийг хүртэл
тэд ийнхүү зөрүүдэлсээр л байх болно. Харин
үүний дараа *Израильчууд бүгд Ертөнцийн Эзэний*
авралыг үзэх бөгөөд Түүний сургаалд бичсэнээр
«Тэрхүү аврагч Сион уулнаас ирнэ.
*Яахобын үр садыг тэр гэмээс нь салгаж өгнө.***



**Тэднийг би гэмээс нь чөлөөлөхдөө тогтоож
өгсөн гэрээгээ биелүүлэх болно» гэсэн үг бий.**
(Ром 11:25-26, ББ).

Ертөнцийн Эзэний үйлс юутай гайхалтай вэ! Исаак
төрсөн учраас үнэнч Элиезер юм өвлөх ямар ч

найдваргүй
хоцорсон шиг
Израилыг
Ертөнцийн
Эзэн өөрийн
ард түмнээр
сонгосон
учраас бусад
үндэстнүүд
Түүнд
хаягдсан мэт
байв. Гэхдээ
тийм биш.



Үнэнч Элиезер шагналаа заавал авна. Их Эзэн
үндэстнүүдийг орхиогүй.

Өөрийн ард түмнээсээ Их Эзэн нүүрээ буруулж, хэсэг
хугацаа орхисон ч тэднийг үнэндээ голоогүй, бүрэн
хаяагүй. Хараагүй нүдийг нь Тэрээр удахгүй нээх
болно. Хатуурсан зүрх сэтгэлийг нь Тэрээр энэрч
зөөлрүүлэх болно.

Энэ бол ямар ч хүний мэргэн ухаанаас давж гарах
Ертөнцийн Эзэний мэргэн ухаан. Зовлонт замыг даван
туулж л байж хүний хатуу зүрх сэтгэл зөөлөрч,
жинхэнэ ойлголтод хүрдгийг Их Эзэн мэднэ. Энэ
замаар л Тэрээр агуу их Хайр Энэрлээ еврейчүүдэд ч,
бусад үндэстнүүдэд ч үзүүлэх боломжтой болох нь
Түүний мэргэн ухааны агуу нууц билээ.



Өмнөх нийтлэлд авч үзсэн «Дэд хууль» 32-р бүлэгт буй Мосегийн зөгнөлийн сүүлийн хэсгийг үзье:

“Намайг, Намайг Тэр гэдгийг одоо мэдэж ав!

Надаас өөр Бурхан байхгүй.

Үхүүлж, амьдруулагч нь Би билээ.

Шархдуулж, эдгээгч нь Би билээ.

Миний мутраас аварч чадах хэн ч байхгүй!

Үнэхээр Би тэнгэр өөд мутраа өргөн

Би мөнхөд амьд! хэмээдэг...

Үндэстнүүд ээ!

Та нар Түүний ард түмэнтэй баярлацгаа!

Учир нь Тэр... Өөрийн газар нутаг болон ард

түмэндээ эвлэрүүлэл хийнэ” гэв (Дэд хууль 32:39-

40, 43; АБ). Сүүлийн ишлэлийн өөр орчуулгыг харахад

бүр тодорхой болно. Үүнд: **“Ард түмнээ Тэр газар**

нутагтай нь хамт гэмээс нь ариутгаж өгнө” (ББ).

Чухам үүнийг Паул бас Ром 11-т бичсэн байдаг! Ард

түмнээ Ертөнцийн Эзэн үхүүлсэн ч дахин амилуулах

өдөр нь ирнэ. Тэднийг шархдуулсан ч эдгээх өдөр нь

айсуй байна.

“«Их Эзэний нэрээр ирсэн хүн ерөөлтэй еэ!» гэсэн

үгийг надад хэлэх тэр үеийг хүртэл та нар дахин

намайг харахгүй...” гэж Есүс хэлсэн (Матай 23:39,

ББ). Хэний ч гаталж чадахгүй өнөөх ангалын билэгддэг

тэр зүрх сэтгэлийн хараагүй байдлыг Их Эзэн хэзээ нэг

өдөр зайлуулах болно. Учир нь, **“ИАВЭ**

хараагүйчүүдийн нүдийг нээдэг...” (Дуулал 146:8;

Исаиа 42:7,16).

Тэр өдөр ард түмнийхээ төлөө эвлэрүүлэл хийж,

гэмийг нь зайлуулаад Үхэгсдийн орны түлхүүрийг

барьж авсан Есүсийг еврейчүүд өөрсдийнхөө хүсэн



хүлээсэн Машиах Хаан болгон таньж, Түүнээс өршөөл гуйж, **“Бүхнийг Захирагч Их Эзэн минь, Та энэрэнгүй нинжин бөгөөд өршөөнгүй сэтгэлтэй билээ. Тусламж эрсэн бүхэнд Та хувиршгүй үнэнч хайраа өгөөмөр ихээр илэрхийлэн харуулдаг билээ... Зовлонд унасан хүний гуйх дууг анхаараач!**

Бэрхшээл зовлон тулгарахад Таныгаа л би дууддаг. Учир нь гэвэл, Та л надад хариу өгдөг шүү дээ...” хэмээн тэд Түүний тусламжийг эрэх болно (Дуулал 86:5-7, ББ).



“Өндөрт, ариун газарт Би оршдог ч Үнэн голоосоо гэмшиж дарууссан хүнтэй Өөрөө Би хамт байдаг.

Даруу хүний сэтгэлийг сэргээж Гэмшдэг хүний оюун санааг шинэчилдэг.

Үргэлж Би маргаад байхгүй

Үүрд уурлаж хилэгнэх үгүй

Эс бөгөөд хүмүүний зүрх мохно.

Миний бүтээсэн амьсгал бөхнө...” гэж Ертөнцийн

Эзэн хэлсэн учраас ийн гуйсан тэдэнд заавал

хариулна (Исаиа 57:15-16). Есүсийг Машиах

Хаанаараа хүлээж авах тэр өдөр еврейчүүд үхэгсдээс

дахин амилах мэт болно (1 Иохан 2:2; Еврей 9:26;

Илчлэл 1:18). Ертөнцийн Эзэн өнөөх “баян хүн”-ийг

анхааран Үхэгсдийн орноос аврах болно гэсэн үг!




Тэр үед тэд: **“Намайг гэсэн энэрэл журам тань агуу. Амийг [еврей: сэтгэлийг] минь Та Үхэгсдийн орны гүнээс аварсан!”** гэж Түүнийг магтах болно (Дуулал 86:13, ББ).

Тэр өдөр Ертөнцийн Эзэн Израилд Өөрийг нь таньж мэдээд зогсохгүй, хайрлан хүндэтгэх цоо шинэ зүрх сэтгэл өгнө (Иеремиа 31:31-37; Езекиел 11:19-20, 36:22-36). Ингээд израилчууд үл итгэх байдлаасаа салах болно (Ром 11:23-25). Есүсийг дагаж үнэнийг мэдэж авах учраас тэд гэмийн буруутгал ба үүнээс ургах сэтгэлийн зовлонгоос чөлөөлөгдөнө. Үнэний хүчээр л хүн эрх чөлөө олдог билээ (Иохан 8:31-32). Тэгээд тэд шударга хаадын ёсоор энэ дэлхийг захирч, ариун тахилчийн ёсоор дэлхийн ард ба Ертөнцийн Эзэний хооронд зуучлах эртний дуудлагаа биелүүлэх болно. **“Бурханы бэлгүүд ба дуудлага нь буцалтгүй ажээ”** (Ром 11:29; Гэтлэл 19:6-г үзнэ үү).

Лазар Есүс Христийг ч билэгддэг

Бүтэн Библийн ишлэл бүрийн тайлбар бичсэн John Gill-ийн дагуу ядуу Лазар Есүс Христ Өөрийг нь төлөөлнө. Учир нь **“Тэр баян байсан боловч ... ядуу болжээ”** (2 Коринт 8:9). **“Тэрээр... Өөрийгөө хоосолж, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр... үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов...”** (Филиппой 2:6-8).





Тэр “Өөрийнхөндөө ирсэн боловч, Өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй” (Иохан 1:11).

Анх ирэхдээ **Машиах Аврагч...**

“...хүмүүст жигшигдэж, зэвүүцлийг амссан.

Уй гашууны хүн, өвчин зовлонг туулагч

Түүнээс бид харин нүүр буруулсан.

Тэрбээр жигшигдэж, бид Түүнийг огоорсон...

Тэрбээр...гэмтэн мэт (тооцогдсон)...” (Исаиа 53:3-

4,12). Үнэхээр фарисайчууд Есүсийг хүлээж авахын

оронд “гэмт хүмүүс”-ийн хамт хооллосных нь төлөө

жигшсэн. Үнэнч шударга байх нь жинхэнэ баялаг

авчирдаг гэж заасных нь төлөө зэвүүцсэн. Эцэст нь

ташуурдуулаад Лазар шиг дүүрэн шарх болсон

Түүнийг тэд Иерусалим

хотоос гаргаж загалмайд

хадахад Есүс “дааман

хаалганы гадаа” (Еврей

13:12) “нохдоор [=харь

үндэстний цэргээр]

хүрээлүүлэн” байж

(Дуулал 22:16) нас

барсан.



Ядуу Лазар Есүс Христийг төлөөлдөг юм бол еврей

бус үндэстнүүдээс Түүний Бие байхаар сонгогдсон

биднийг ч төлөөлнө гэсэн үг. Сүнсээрээ, ядуу дорой

Лазараас ямар ч ялгаагүй байсан *биднийг Есүс “баян*

болгохын тулд... ядуу болжээ” (2 Коринт 8:9).

“Биднийг дорой байхад... биднийг нүгэлтнүүд

байхад Христ бидний төлөө үхсэн” (Ром 5:6,8). Есүс

Христ бидний хамт “нохдын дунд сууж” зовлон дүүрэн

байдлыг маань хуваалцаж, Өөрийгөө бүхий л талаар

бидэнтэй адилтган, гэм бурууг маань хүртэл үүрч,



зайлуулсан. Харин “загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай” байсан Түүнийг Ертөнцийн Эзэн “үлэмжийн дээдээр өргөмжилсөн...” (Филиппой 2:8-9)! Тэгэхэд Түүний Бие болох биднийг Түүнтэй хамт өргөмжилсөн! Түүнтэй нэгдэн “Түүний дотор” байдаг бид Түүнтэй хамт нас барж, хамт дахин амилж, хамт тэнгэрлэг газарт очин тэнд Түүний бүхий л сүнслэг ивээл, баялгийг хуваалцан байж, Түүнтэй хамт Ертөнцийн Эзэн Эцгийн баруун талд суулгасанд тооцогддог (Ром 6:3-11; Колоссай 1:27; 2:2-3; Эфэс 1:4; 2:5-7)!

Ертөнцийн Эзэний үнэнд тооцсон зүйл зайлшгүй биелдэг. Нохдын дунд суудаг байсан, хэнд ч хэрэггүй Лазар, Абрахамын цээж налан суусан нь ямар ч итгэл найдваргүй суусан, еврей бус үндэстнүүдээс гаралтай бидэнд юутай агуу найдвар, ирээдүй байгааг харуулж байна.

Энэ бүхний биеллийг итгэлтэйгээр хүлээж байхдаа бид энэ дэлхийд Есүсийн тээсэн зовлонг хуваалцах агуу эрх завшаантай билээ. **“Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус, Түүний төлөө бас зовох нь та нарт соёрхогджээ”** (Филиппой 1:29). Эрүүл хүн зовохоос аль болох зайлсхийдэг ч гэсэн зайлшгүй зовлон тохиолдоход бид үүнийг давуу эрх гэж үзэх ёстой гэсэн үг. Гашуун зовлон бидэнд **“Христийг болон Түүний амиллын хүчийг таньж, зовлонгоос нь (хуваалцах)”** боломж хайрладаг (Филиппой 3:10). Чухам энэ бол Иовын зовлонт туршлагаараа олж авсан баялаг: **“Таны тухай би чихээрээ л сонсдог байлаа. Тэгтэл одоо үүнийг нүдээрээ үзэж байна”** (Иов 42:5).



Ийнхүү “агшин
зуурын ялихгүй
зовлон нь алдрын
мөнхийн жинг
бидэнд үлэмж
арвижуулж байна”

(2 Коринт 4:17).

Тийм ч учраас

“Христийн төлөө

буруутгагдах нь

Египетийн [=энэ

дэлхийн] эрдэнэсээс агуу их баялаг мөн гэж (Моше)

үзжээ. Учир нь тэр шагналыг харж байлаа” (Еврей

11:26). Энэ дэлхийд харснаараа биш, итгэлээрээ

алхахад дуудагдсан бид Мосегийн энэ хандлагыг

дуурайн тэр агуу их шагналыг харан байж хүртэцгээе!

Харин Моше биш, Абрахам энэ өгүүллэгийн гол дүр

болсны учир, Ертөнцийн Эзэнд итгэсэн түүний итгэлд

оршино (Ром 4:3). Нүдэнд харагдахуйц бодит байдлыг

зөрчдөг Их Эзэний Үгэнд итгэх тэрхүү агуу итгэлийг Их

Эзэн Өөрөө Абрахамд өгчээ. Элиезерт ч гэсэн тийм

итгэл байсан. Христийн Биеийн гишүүд болох бидэнд ч

гэсэн Тэр Өөрийнх нь Үгэнд итгэх итгэлийг янз бүрийн

хэмжээгээр хайрласан билээ (Ром 12:3).



Эцсийн дүгнэлт

Христчин уламжлалын дагуу баян хүн, ядуу Лазар
хоёрын тухай өгүүллэг нас барсан ч амьдаараа там,

диваажин хоёрт очсон хоёр хүний түүх. Гэвч уг

өгүүллэгийг болсон явдал гэж авч үзэхээр Библийн

бусад сургаалтай авцалдан нийцэхгүй, дотроо ч олон



зөрчилдөөнтэй болохыг нь бид олж харж, тайлахын аргагүй олон асуудалтай тулгардаг. Тиймээс энэ өгүүллэг Есүст итгээгүй хүн бүр аймшигт тамыг зорьж буйг хэлээгүй нь ил байна. Тамын тухай ойлголт бол Ертөнцийн Эзэний Үгээс биш, Есүсийн дайсан болох фарисайчуудын гаж сургаалаас үүссэн онол болох нь харагдсан. Мөнхөд үргэлжлэх галт тамын тухай уламжлалын сургаал Библийн хаанаас ч олохгүй.

Христчин энэ буруу уламжлалыг орхих дургүй хүн энэ судалгаанд гаргаж тавьсан бодит баримтад хэрхэн хандахаа бодох ёстой. Бидний энд бичсэн зүйлд “итгэхгүй байна, буруу юм бичсэн байна” гэж хэлэх нь хангалтгүй! Харин бидний гаргасан нотолгоо бүр яагаад хүчингүй болохыг харуулж, зүй ёсоор няцаах хэрэгтэй. Үүнээс гадна өөрийнх нь ойлголт хэрхэн Библийн бүх сургаалтай авцалдан нийцэн, яагаад зөв болохыг нотлон үзүүлэх ёстой. Бид лав хувьдаа фарисайчуудын сургаалыг дагахгүй, Есүс Христийг Библид харш сургаал заасан гэж сурталчихгүй, харин зөвхөн Ертөнцийн Их Эзэний Үгийг л дагахаар шийдсэн.

Есүсийн өгүүллэг үнэндээ энэ дэлхийн бүх хүмүүсийг агуулсан Ертөнцийн Эзэний агуу их төлөвлөгөөг илчилдэг сургаалт зүйрлэл болох нь ил тод харагдсан. Баян хүн иудейчүүдийг, ядуу Лазар бусад үндэстнүүдийг төлөөлдөг





болохыг мэдэж авахдаа л тэдний хувь заяа нь өөрийнх нь үйлс болон Ертөнцийн Эзэний шударга ёс ба хайр энэрэл дээр үндэслэсэн болохыг бид ойлгоно.

Еврей бус үндэстнийх болох бидэнд илгээгдсэн элч Паулын хамт аялдаг байсан Лук энэ өгүүллэгийг бичиж үлдээсэн юм. Абрахамын үнэнч даамал зарц Элиезер шиг харснаараа биш Ертөнцийн Эзэний Хэн болоход итгэх итгэлээр амьдрах хүн Абрахамын хүү болж, Ертөнцийн Эзэний түүнд өгсөн амлалтыг хүртэх болсныг энэ өгүүллэг харуулахыг зорьжээ. Харин Абрахамын үр удам болох Иуда хэмээх баян хүн онгирон сагсуурсны улмаас Ертөнцийн Эзэнд гологдож Түүний Оршихуйгаас цөллөгдсөн. Тэглээ гээд еврей бус бид бардамнах ёсгүй. Израилчуудад Их Эзэн мөнхөд уурлахгүй, хэзээ нэг өдөр тэднийг ч энэрэн аврах болно. Бидний Их Эзэн өрөвч нинжин, өршөөнгүй, туйлын үнэнч, бидний сул доройг даах чадвартай, төгс найдвартай учраас амлалтаа заавал, амласан хүндээ биелүүлэх болно!

Бүхнийг захирагч Их Эзэн минь!

Бүтээсэн бүх үндэстнүүд тань өөрийн тань өмнө ирээд өвдөг сөгдөх болно. Тиймээ, Бүхнийг

Захирагч Их Эзэн минь,

Таны нэрийг тэд магтан хүндлэх болно.

Учир нь, Та бол аугаа хүчирхэг агаад асар гайхамшигтай үйлсийг бүтээгч нь мөн болой.

Та бол цор ганцаараа Ертөнцийн Эзэн болой.

Мөнхийн Эзэн минь! Өөрийнхөө замыг Та наддаа зааж өгөөч!



Тийнхүү би үнэнийг тань баримтлан явна. Нэрийг
тань сонсонгуутаа эмээн хүндэлж байх хоёргүй
үнэнч сэтгэлийг наддаа Та өгөөч!
Бүхнийг Захирагч Их Эзэн, Ертөнцийн Эзэн минь!
Чин сэтгэлийн угаас Тандаа би талархаж байна.
Таныхаа нэрийг би үеийн үед магтана. Учир нь
гэвэл, надад харуулсан хувиршгүй үнэнч хайр тань
аугаа их билээ. Намайг Та үхлийн гүн булшнаас
авран чөлөөлсөн шүү дээ!
(Дуулал 86:8-13, ББ)

□

Баян хүн ба Лазарын өгүүллэгт орсон билэг тэмдэг	
Баян хүн	Тэргүүн тахилч Каиаф, Яакобын Иуда буюу иудейчүүд
-нил ягаан өнгөтэй	Хаанчлалын үүрэг
-маалинган хувцас	Тахилчийн үүрэг
-тансаг зоог	Ертөнцийн Эзэний бүх сүнслэг ивээлүүд
Лазар	Абрахамын итгэмжтэй даамал Элиезер, еврей бус үндэстнүүд, Марта Мариа хоёрын ах Лазар, Есүс Христ ба Түүний Бие
-ядуу	Ертөнцийн Эзэний амлалт, сүнслэг ивээлүүдийг аваагүй
-ноход	Еврей бус үндэстнүүд
нас барах	амьдралын нөхцөл байдалд том өөрчлөлт орох
тэнгэрэлч	Их Эзэний сайн мэдээ хүргэдэг элч төлөөлөгч
Абрахамын өвөр дээр суух	Абрахамын хүү болж, түүнд өгсөн Ертөнцийн Эзэний амлалт ивээлүүдийг хуваалцан эдлэх, Хаант Улсад хамт зооглох
Үхэгсдийн орон	Үзэгдэхгүй байдал, харьцаагүй байдал
галын дөл	Хэл яриагаар үйлдсэн гэм
галд шатан тарчлах	Сэтгэл санааны хувьд их шаналан зовох
гүн ангал	Еврейчүүдийн ойлгох чадварыг хаадаг хаалт (бүтээлэг)
-Иордан гол мэт	Ертөнцийн Эзэний амласан бүхний хил хязгаар болох аврал, энэ дэлхийгээс тусгаарлах үхэл



Ашигласан эх сурвалж:

- Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.
- Brown, C. (1975). The New International Dictionary of New Testament Theology.
- Bullinger, E. W. (1902). The Rich Man and Lazarus: An Intermediate State? <http://www.biblical-data.org/LAZARUS.pdf>
- Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife. www.truthaccordingtoscripture.com
- Eby, J. P. (n.d.). Abraham's bosom: A treatment of the parable of the rich man and Lazarus. <https://godfire.net/eby/abrahams.html>
- Froom, L. E. (1966). Gravity of Ascribing False Teachings to Christ. www.truthaccordingtoscripture.com
- Gill, John (1690-1771). Exposition of the Entire Bible. www.biblehub.com
- Huie, B. T. (1998). Lazarus and the rich man. www.tentmaker.org
- Leiter, S.Y. (2003). Grasping the Heel of Esau. www.chabad.org
- Martin, E. L. (2003). The real meaning of Lazarus and the rich man. <http://www.what-the-hell-is-hell.com/HellArticles/RichManParable.htm>
- Smith, L. R. (n.d.). Lazarus and the Rich Man: A scriptural journey through the intriguing parable of Lazarus and the rich man. www.bible-truths.com
- Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Patching, J. The rich man and Lazarus. <http://www.tentmaker.org/books/RichManandLazarus-Patching.html>
- Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org
- Wilson, Larry (2007). The rich man and Lazarus. Wake up America Seminars. www.wake-up.org
- Witherell, J. F. (1843). Rich man and Lazarus. In *Five Pillars in the temple of partialism removed*. Concord: Balm of Gilead.